

## СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА, БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аж ахуй нэгж байгууллагад Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн саналыг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар олгоно.

### БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ:

Бүрдүүлэх материал	Тайлбар
<b>Тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг</b>	Эрхлэх үйлчилгээний төрөл, оноосон нэр, байршил, хаяг, харилцах утас, цахим хаяг зэргийг тодорхой дурдах
<b>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</b>	-
<b>Улсын байцаагчийн дүгнэлт</b>	Хүнс хөдөө аж ахуйн газрын Улсын байцаагчийн ажлын байрны дүгнэлт
<b>Галын аюулгүй байдлын дүгнэлт</b>	Тухайн үйл ажиллагаа эрхлэх байранд хийгдсэн Онцгой байдлын газраас галын дүгнэлт
<b>Хяналтын камерын тодорхойлолт</b>	Цагдаагийн газраас “Хяналтын камерын шаардлага хангасан тухай тодорхойлолт” (MNS 6423 стандартад нийцсэн камерын системээр тоноглогдсон, камер /шөнийн цагаар зураг авдаг бичлэгийг 720 цагаас багагүй буюу 30 хоног хадгалдаг санах ойтой байх/ -ын байнгын ажиллагааг хангасан байх)
<b>Тохирлын гэрчилгээ</b>	Стандарт хэмжил зүйн хэлтсээс Тохирлын гэрчилгээ
<b>Гадаад орчны зураг</b>	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрт харьяалагдах эзэмшил газрынхаа 30-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний талбайд ногоон байгууламж, автомашины зогсоол төлөвлөж, бий болгосон байх

**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУРААМЖ  
(УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ)**

**СОГТУУРУУЛАХ УНДААГАА ХУДАЛДАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ:**

Сумдууд	Шинээр тусгай зөвшөөрөл олгох	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах
Дархан сум	<b>1,000,000</b>	<b>300,000</b>
Орхон сум	<b>500,000</b>	<b>200,000</b>
Хонгор сум		
Шарын гол сум		

**СОГТУУРУУЛАХ УНДААГААР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ:**

Сумдууд	Шинээр тусгай зөвшөөрөл олгох	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах
Дархан сум	<b>500,000</b>	<b>300,000</b>
Орхон сум	<b>300,000</b>	<b>100,000</b>
Хонгор сум		
Шарын гол сум		

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУРААМЖ ТӨЛӨХ МЭДЭЭЛЭЛ**

1. itax.mta.mn-аар нэвтэрч, төлбөрийн даалгавар үүсгэнэ.

The screenshot shows the 'Receipt Create' page on itax.mta.mn. It features a grid of 12 tax categories with icons: Улсын тэмдэгийн хураамж, Иргэний үл хөдлөх хөрөнгө, Бичил үйл ажиллагааны орлогын албан татвар, Хог хаягдлын үйлчилгээний хураамж, Ойн нөөц ашигласны төлбөр, Ан амьтаны нөөц ашигласны төлбөр, Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр, Ахуйн хэрэглээний ус, рашаан ашигласны төлбөр, Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, Татварын хүү торгуулын орлого, АМНАТ - банкны суугасан. Below the grid are input fields for 'Татаар төлөгчийн регистрийн дугаар' (2050668), 'Татаар төлөгчийн дугаар' (Дархан-Уул), 'Төлбөр хураамжийн төрөл' (4 - Бусад), 'Аймаг/ Дүүрэг' (19 - Дархан-Уул), 'Сум/хороо' (1998 - Аймгийн төвлөрсөн), 'Хүлээн авагч байгууллага' (9025227 - Дархан-Уул аймгийн заса), 'Төлөх дүн' (0.00 ₮), and 'Утас'. There is a 'G'm not a robot' checkbox and 'Үүсгэх'/'Буцах' buttons.

2. Нэхэмжлэлийн дугаараар хураамжийг банканд төлж, баримтыг материалд хавсаргана.

The screenshot shows a green confirmation message: '✓ Амжилттай: 2240207364084 - Дугаартай төлбөрийн даалгавар үүслээ!'. Below it is a table with the following data:

Нэхэмжлэлийн дугаар	Дүн	Үүсгэсэн огноо	Үйлдэл
2240207364084	300000	2024-02-22 13:42:04	Харах Төлөх

Buttons 'Үүсгэх' and 'Буцах' are visible above the table.